

**2023**



**ЖИЛИЙН  
ТАЙЛАН**



**ХААБ**  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ



# АГУУЛГА

ОРШИЛ

ОНЫ ТОВЧООН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

АРИЛЖАА

ЗАХ ЗЭЭЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ГИШҮҮНЧЛЭЛ

ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ

МАРКЕТИНГ

ЗАХИРГАА, УДИРДЛАГА

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГ

САНХҮҮ, АЖ АХУЙ

ГАДААД ХАРИЛЦАА

ХҮНИЙ НӨӨЦ

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

СУРГАЛТ, ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭ

ДҮГНЭЛТ



# ОРШИЛ

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь 2023 онд Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх зорилгыг дэвшүүлэн ажиллалаа.

Хөдөө аж ахуйн бирж ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан бүтэц орон тооны дагуу 5 нэгж 36 ажилтны бүрэлдэхүүнтэй биржийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам, Засгийн газрын хөтөлбөр, тогтоол, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны бодлого, албан даалгавар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Дээрх бодлого шийдвэрийн хүрээнд 2023 онд бирж нь дунд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

## Үүнд:

Зүүн бүсийн аймгуудад “Ноолуурын дуудлага худалдаа” зохион байгуулсан.

Малчин, үйлдвэрийг холбосон дундын зуучлалгүй “Малын төвлөрсөн арилжаа”-г Төв аймгийн Аргалант сумын “Ложистикийн төв”-д амжилттай зохион байгуулсан.

Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын гэрчилгээг цахимаар шийдвэрлэх “Экспортын нэг цонхны систем”-ийг нэвтрүүлж ажилласан байна.





# ОНЫ ТОВЧООН



968 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулсан



Зүүн бүсийн аймгуудад “Ноолуурын дуудлага худалдаа”-г зохион байгуулсан. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын малчид болон дотоодын ноолуурын үйлдвэрүүдүүд дунд зохион байгуулагдсан.



Бүгд Найрамдах Узбекистан Улсын бараа түүхий эдийн бирж “UZEX”-тэй хамтран ажиллах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурж хамтран ажиллах болсон.



Төв аймгийн Аргалан суманд байрлах биржийн "Ложистикийн төв" дээр "Малын төвлөрсөн арилжаа"-г зохион байгуулсан. Малчин, үйлдвэрийг холбосон дундын зуучлалгүй тус арилжаанд 4 аймгийн 10 гаруй сумдаас ирсэн малчдын 2014 гаруй бог малын арилжаа зохион байгуулсан.



“Экспортын нэг цонхны систем”-ийг нэвтрүүлэн мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын бүрдүүлэлтийг хийх нэг удаагийн гүйцэтгэлийн хугацааг 316 цагаас 72 цаг хүртэл бууруулан, хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орсноор “50” гаруй баримт бичгийг “11+4” болгон багасгаж чадлаа. Тайлант хугацаанд 696 экспортын үйл ажиллагааны хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, 27,695.37 тонн мах экспортод гаргаад байна.



“Биржийн байнгын бус гишүүн хоршоо, үйлдвэр хоорондын арилжаанд багцын гэрээний систем”-ийг нэвтрүүлэхээр хөгжүүлсэн ба Баялаг гүрэм хоршоон дээр НӨАТ илгээн тест хийсэн бөгөөд систем хэрэглээнд нэвтрэхэд программ хангамжийн хувьд бэлэн болон байна.



# ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь түүхий эд бэлтгэн нийлүүлэгч малчин, тариаланч, хоршоо, үндэсний үйлдвэрлэгчдийн хооронд хийгдэх бараа, түүхий эдийн арилжаа, болон бараа, түүхий эдийг экспортод гаргах арилжааг зохих журмын дагуу зохион байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бий болгох чиг үүрэг бүхий төрийн өмчит компани юм.

Хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих тогтолцоог хөгжүүлэх замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

2013-2023 оны байдлаар нийтдээ 7 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа зохион байгуулсан бол өнгөрөгч онд 968 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулсан жил байлаа. Бид биржийн арилжаанд оролцогчдын тоо нэмэгдүүлэх, хоршоо үйлдвэр холбосон арилжааг өргөжүүлэх, махны экспортыг нэг цонхны бодлогоор явуулах зорилгоор

“Экспортын нэг цонхны систем”-ийг нэвтрүүлж, цахим бирж болох, арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн платформ системийн хүрээнд амьд малыг дуудлагаар худалдах, Бирж, татварын байгууллага болон биржийн байнгын бус гишүүн хоршооны хооронд “Багцын гэрээ”-ний системийг хөгжүүлж, гадаад хамтын ажиллагааны хүрээнд гаднын орнуудын биржүүдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах зэрэг томоохон гол гол арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Цаашид бид Биржийн зах зээлийн зохицуулалт эрх зүйн орчныг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, биржийн дэд бүтцийг сайжруулах, мэдээлэл технологийн цахим шинэчлэлт хийхээр зорин ажиллаж байна.

Бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд, хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэгч малчид, хоршоо, үйлдвэр, түүхий эд худалдан авагч, биржийн гишүүн брокерууд та бүхэндээ ажлын амжилт хүсье.

Хүндэтгэсэн,  
Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
Ц.Батсайхан





# АЛСЫН ХАРАА, БИДНИЙ ИРЭЭДҮЙ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын орлогыг өсгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

## ЗОРИЛТ

Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, Зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, Ложистикийн төвийг бий болгох, зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, Зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх, Компанийн засаглалыг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

## ҮНЭТ ЗҮЙЛС

Нэр хүнд, Хариуцлага, Үнэнч шударга зарчим, Мэргэшсэн боловсон хүчин, Ёс зүй, Дэвшилтэт технологи, Багаар ажиллах чадвар



# АРИЛЖАА

Тайлант хугацаанд 220 удаагийн арилжаа зохион байгуулж, нийт 968.2 тэрбум төгрөгийн 1662 хэлцэл хийгдсэн. Үүнд 6300 тонн ямааны ноолуур, 2379 тонн ямааны завод ноос, 10554.4 тонн хонины ноос, 987 тонн тэмээний ноос, 22321 тонн тосны ургамал /рапс/, 16.0 тонн тэмээний очёс, 228 тонн завод ноос, 8.6 тонн бодын хөөвөр, 4400 ширхэг үхрийн шир, 1441 толгой амьд мал зэрэг бараа, түүхий эдийг арилжсан байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 89,1 хувийг ямааны ноолуур, 5 хувийг ямааны завод ноос, 5 хувийг бусад бараа түүхий эдийн арилжаа эзэлж байна.

Арилжсан бараа, түүхий эдийн тоон үзүүлэлтийг урьд онтой харьцуулахад ямааны ямааны ноолуур- 20% хувиар, тэмээний ноос- 32 хувиар, хонины ноос- 51 хувиар буурсан бол завод ноос -18 хувиар, тосны ургамал 2.5 дахин өссөн байна.

## Арилжааны үнийн дүн /тэрбум ₮/





## Арилжааны үнийн дүн, хэмжээ (өмнөх онтой харьцуулсан)



Компаний 2023 оны бизнес төлөвлөгөөгөөр 780,1 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулахаас 968,2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж төлөвлөгөөгөө 124 хувиар буюу 188.1 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд 7 байнгын гишүүн брокерын компани, 1 байнгын бус гишүүнээр /хоршоо/ зуучлуулан 68 аж ахуйн нэгж биржийн арилжаанд оролцон 1568 ширхэг бараа, түүхий эдийн экспортын тодорхойлолт авсан байна.

### НООЛУУРЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Дорнод, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар болон Хүнс, Хөдөө аж ахуйн газартай хамтран 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 2-ны өдрийн хугацаанд хоршоод, малчдын түүхий эдийн борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэр, худалдан авагчдад худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой “Ноолуурын дуудлага худалдаа”-г Дорнод аймгийн Хэрлэн сумын “Талын түмний хүч” хоршооны байранд, Хэнтий аймгийн Ханбүргэдэй ХХК-ийн түүхий эдийн агуулах,



Өмнөдэлгэр сумын Соёлын төв дээр тус тус зохион байгууллаа. Дорнод аймгийн дуудлага худалдаанд нийт 1,883 кг ноолуур орсоноос “Талын түмний хүч” хоршооны 500 кг ноолуурыг 1 кг-ыг нь 160,000 төгрөгөөс эхлэн дуудаж, 173,550 төгрөгт хүрч, 86,775,000 төгрөгөөр “Сор кашимер” ХХК компани худалдан авсан.

Дуудлага худалдаанд Дорнод аймгийн 5 сумдын хоршоод, малчид оролцож, худалдан авагч талаас “Сор кашимер” ХХК, “Натурал Файбр” ХХК, “Хатант” ХХК болон 5 иргэн оролцсон.

Хэнтий аймгийн хувьд худалдан авах сонирхолтой аж ахуй нэгж, дотоодын үйлдвэр, төлөөлөгч, ченж, хоршоод байсан боловч энэ жилийн өвөлжилт хүндрэлтэй байсны улмаас ноолуур самнах хугацаа хойшилсон, мөн малчдын ойлголт муу байснаас шалтгаалан ноолуур худалдах малчин хоршоо байхгүй байсан.

Өмнөговь аймгийн Номгон сумын “Хөрхийн наран” хоршооны агуулахаас 10,000 кг боловсруулаагүй, цайвар, нас гүйцсэн ямааны ноолуурыг арилжин Өгөөж шим ХХК-д худалдан борлууллаа.



## МАЛЫН ТӨВЛӨРСӨН АРИЛЖАА

2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Төв аймгийн Аргалан суманд байрлах биржийн “Ложистикийн төв” дээр “Малын төвлөрсөн арилжаа”-г зохион байгуулсан.

Малчин, үйлдвэрийг холбосон дундын зуучлалгүй тус арилжаанд 4 аймгийн 10 гаруй сумдаас ирсэн малчдын 629 толгой бог малыг “Мах Импэкс” ХК, “Агро нэгтгэл трейд” ХХК, “Кенбо” ХХК, “Дэлгэрэх” ХХК зэрэг мах боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх спот гэрээний, 600 бог малын форвард гэрээний арилжааг тус тус хийсэн. Мөн 2023 оны 11 дүгээр сард Малын Удмын Сангийн Үндэсний төв, Увс, Завхан аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран МУСҮТ-ийн цөм сүргийн салбар нэгжийн ялган төвлөрүүлсэн малаас Увс аймагт 435 толгой бог, Завхан аймагт 350 толгой бог малыг тус тус зах зээлд биржээр дамжуулан нийлүүлэх малын форвард гэрээний арилжааг зохион байгууллаа.





# ЗАХ ЗЭЭЛ, СУДАЛГАА

Тайлант хугацаанд биржийн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, арилжааг боловсронгуй, бодитой зохион байгуулах, биржээр арилжих бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх зорилгоор дараах судалгааны ажлуудыг хийлээ.

## Үүнд:



Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын дагуу бэлтгэгдсэн малыг малчид, хоршоодоос шууд мал төхөөрөх, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулах зураглалыг гаргахын тулд “Мал, мах биржээр арилжих боломж”-н талаар судалгааг анхдагч болон хоёрдогч эх сурвалж, бусад эх үүсвэрийн судалгаануудад тулгуурлан хийсэн.



Сүүлийн жилүүдэд хуш модны самар бүртгэлгүй, хамгийн бага үнээр гаалиар гарч байна гэсэн үндэслэлүүдийн хүрээнд “Хуш модны самрыг биржээр арилжих нөөц боломж”-н талаар судалгааг анхдагч болон хоёрдогч эх сурвалж, бусад эх үүсвэрийн судалгаануудад тулгуурлан хийсэн



“Экспортын нэг цонхны систем”-ийн судалгаа, нэвтрүүлэлт. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 9 дүгээр сарын А/294 дүгээр тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Болорчулуунаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан, 2022 оны 11 дүгээр сарын А/372 дүгээр тушаалаар Дэд сайд М.Ганхүлэгээр ахлуулан Хүнс, хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Махны холбоо болон “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн оролцоотойгоор шинэчлэн байгуулсан. Экспортын нэг цонхны системийг нэвтрүүлснээр мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын бүрдүүлэлтийг хийх нэг удаагийн гүйцэтгэлийн хугацааг 316 цагаас 72 цаг хүртэл бууруулах болон хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орсноор 50 гаруй баримт бичгийг “11+4” болгон цөөрүүлсэн. Тайлант хугацаанд мах, махан бүтээгдэхүүн экспортлогч 107 аж ахуйн нэгж бүртгүүлж, 143 экспортын эрхтэй төлөөлөгчөө томилоод байна. 527 удаагийн экспортын хүсэлтийг системээр дамжуулан гүйцэтгээд байна.




# ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1662 хэлцлийн худалдах, худалдан авах гэрээг баталгаажуулж, 968.3 тэрбум төгрөгийн спот гэрээний төлбөр тооцоог хийж гүйцэтгэлээ.

Гэрээний төлбөр тооцоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Тус хугацаанд нийт 38.4 тэрбум төгрөгийн дэнчин, 82.8 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийн гүйлгээ хийгдэж, тайлант хугацаанд клиринг, төлбөр тооцооны аливаа эрсдэл гараагүй, төлбөр тооцоо хугацаандаа хийгдсэн болно.

## Гэрээний төлбөр тооцооны дүн



Форвард гэрээг арилжихтай холбогдуулан Клиринг, төлбөр тооцооны журмын заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн найруулж 6 дугаар сарын 27-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/83 дугаар тушаалаар батлууллаа.

“Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлэх, байгууллагын эрсдэлийг тодорхойлох, “Эрсдэлийн удирдлагын хороо”-ны гишүүдээр дамжуулан байгууллагын эрсдэлийг тогтмол бүртгэлжүүлж, үнэлэх, төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг гаргах ажлыг зохион байгуулан, нэгтгэн боловсруулж, зөвлөмж гарган ажиллалаа.




# ГИШҮҮНЧЛЭЛ БҮРТГЭЛ


## БИРЖЭЭР АРИЛЖААЛАХ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ

2023 оны эцсийн байдлаар 220 удаагийн арилжаа зохион байгуулагдаж, агуулахын удирдлагын системд бүртгүүлсэн 13 итгэмжлэгдсэн агуулахын бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээнд 24 удаа биет болон цахимаар хяналт хийж бараа, түүхий эдийн харагдах байдлыг фото зургаар баримтжуулан

“Агуулахын нөөцийн мэдээлэл” бүртгэх маягтад холбогдох агуулахын ажилтнаар гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан.

График 1. Агуулахын удирдлагын системд бүртгүүлсэн бараа, түүхий эдийн хэмжээ. /2023 оны 12 сарын 28-ны байдлаар/







**АГУУЛАХ:**

Биржийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрийн дэргэдэх агуулахын тоог хоёроор нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Файнноос” ХХК, “Стар импекс” ХХК-ийн үйлдвэрийн дэргэдэх агуулахын итгэмжлэлийн хугацааг сунгаж, шинээр бичиг баримт, шалгуур үзүүлэлтийг хангасан “Торгон шир бэлтгэл” ХХК, “Сүмбэркоммодитиз” ХХК, “Ахисан түвшин” ХХК, “Говь” ХХК,

“Хатант-интернейшнл” ХХК-тай 3 жилийн хугацаатай гэрээ байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг давуулан биелүүлжажиллалаа.







## БАЙНГЫН ГИШҮҮН:

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй "Хаан Тэлмэн" ХХК, "Ханбүргэд Хэнтий" ХХК, "Алтаншагай импекс" ХХК-ийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, Гишүүнчлэлийн гэрээг сунгасан. "Бадархундага Оргил" ХХК, "Роял кашимер" ХХК-тай байнгын гишүүний гэрээг байгууллаа.

"Бадархундага Оргил" ХХК, "Ханбүргэд Хэнтий" ХХК, "Алтаншагай импекс" ХХК, "Хаан Тэлмэн" ХХК, "Цэц-Инвест" ХХК, "Суварга Алтай констракшн" ХХК-уудын клирингийн эрхийн гэрээг Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтсээс ирүүлсэн мэдээллийг үндэслэн сунган ажилласан. Мөн "Бадархундага Оргил" ХХК-д 9, "Ханбүргэд Хэнтий" ХХК-д 13, "Алтаншагай импекс" ХХК-д 10, "Хаан Тэлмэн" ХХК-д 10, "Цэц-Инвест" ХХК-д 10, "Суварга Алтай констракшн" ХХК-д 2 харилцагчийн эрхийг шинээр нээлээ.

Биржийн арилжаанд оролцох мэргэжлийн оролцогчийг бэлтгэх, мэргэшүүлэх зорилгоор "Брокерын эрх олгох" сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн мэргэжлийн холбоотой хамтран 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 12-ны өдрүүдэд 25 оролцогчийг хамруулан зохион байгуулан гэрчилгээг олгосон.

Итгэмжлэгдсэн агуулахын бараа, түүхий эдийн чанар хариуцсан ажилтан, биржийн байнгын гишүүн барааны брокерыг чадавхжуулах "Биржийн барааны код олгогч"-ийн цахим сургалт зохион байгуулах ажлын болон сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан 6 сарын 22-ны өдөр 38 оролцогчийг хамруулан зохион байгууллаа.

2023 оны IV улирлын байдлаар 18 аймгийн 70 сумын 86 хоршоотой байнгын бус гишүүний гэрээ байгуулаад байна. Эдгээр хоршоодтой дараах байдлаар хамтран ажиллалаа.


2023 оны 5 сарын 24, 25-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан Хангайн бүсийн хоршоод, мах боловсруулах үйлдвэрийн бизнес түншлэл "Махны форум" уулзалт хэлэлцүүлэгт Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Дундговь, Говь-Алтай зэрэг 6 аймгийн 58 төлөөлөл оролцож "Мал, мах бэлтгэлийн оролцогч талуудад үүсч байгаа саад бэрхшээл түүний шийдэл" сэдвээр хэлэлцсэн. Хэлэлцүүлгээс Хоршоо, махны үйлдвэрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, түүхий эд худалдан авах эргэлтийн хөрөнгийг хөнгөлөлттэй зээлээр шийдэж өгөх, Эрүүл бүс буюу хамгаалагдсан бүсийг үйлдвэр болон хоршооны дэргэд бий болгох зэрэг асуудлыг дэвшүүлсэн.



Мөн Хэнтий аймгийн хоршоологчдын зөвлөгөөнд оролцож буй 15 сумын 63 хоршоонд биржийн үйл ажиллагаа болон байнгын бус гишүүн, итгэмжлэгдсэн агуулахын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулга мэдээллийг өгч, биржийн байнгын бус гишүүн 5, итгэмжлэгдсэн агуулахын 17 төлөөлөлтэй цаашид хэрэгжүүлэх ажлын талаар уулзалт, хэлэлцүүлэг хийсэн.

2023 оны 6 сарын 30-ны өдрөөс 7 сарын 01-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод биржийн үйл ажиллагааг сурталчлан таниулах “Ургадаг цагаан алт” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр цахилгаан хайчаар хонь ноослох DEMO үзүүлбэр болон хяргасан ноосыг ангилан ялгах талаар сургалт хийж, ангилан ялгалт хийсэн ноосыг үндэсний үйлдвэрлэгч нарт чанартай нь уялдуулан ялгаатай үнээр борлуулах замаар малчид, хоршоод орлогоо нэмэгдүүлэх боломжийг сурталчилан таниуллаа.

### 18 АЙМГИЙН 70 СУМЫН 86 ХОРШОО



Биржийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, хоршоо биржээр хэрхэн арилжаанд оролцох тухай цогц мэдлэг олгох сургалт зохион байгуулах, хоршооны агуулахыг итгэмжлэх, хоршоог биржийн байнгын бус гишүүнээр элсүүлж гэрээ байгуулах зорилгоор Өвөрхангай аймагт 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 9 дүгээр сарын 23-ны өдрийн хугацаанд албан томилолтоор ажилласан. Тус арга хэмжээнд аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, аймаг, сумдын мэргэжилтнүүд, хоршоодын төлөөлөл зэрэг нийт 22 оролцогч идэвхтэй хамрагдлаа.

Биржийн үйл ажиллагааг Дундговь аймагт сурталчлан таниулах, хоршоодыг байнгын бус гишүүнээр элсүүлэх, гэрээ байгуулах, сунгах, биржийн арилжаанд оролцох эрх олгох, бараа, түүхий эдийн агуулахыг итгэмжлэх зорилгоор Дундговь аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн Хоршоологчдын холбоотой хамтран 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 28-ны өдрийг дуустал Мандалговь, Адаацаг, Дэрэн сумд албан томилолтоор ажиллан 6 байнгын бус гишүүн, 5 агуулах итгэмжлэлийн гэрээ байгуулсан.



# ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд 220 удаагийн цахим арилжаа явагдсанаас 1662 хэлцэл биелсэн байна. Энэхүү цахим арилжаанд нийт 28 удаагийн системийн асуудал үүссэнийг цаг тухай бүрт алдааг хянан засварлаж, байгууллагын үйл ажиллагааны болон бизнесийн эрсдэл, доголдол үүсгэлгүй ажиллалаа.

“Айтүүлс” ХК-тай “Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн ашиглалтад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх” гэрээ байгуулсан. Гэрээний дагуу засвар болон нэмэлт хөгжүүлэлтийн 22 ажлыг хийж гүйцэтгэсэн. Арилжаа төлбөр тооцооны системийн өгөгдлийн санг нээлттэй эх бүхий PostgreSQL өгөгдлийн сан руу шилжүүлэх ажил, тестийн хувилбарыг системийн үндсэн хувилбартай ижил болгох, дуудлага худалдааны модулийг бүрэн шинэчилж хэвийн ажиллагаанд оруулсан. Форвард, Фьючерс, Опцион гэрээний хувьд системд гэрээгээ үүсгээд хэлцэл биелж байгааг тестийн орчинд 8 удаа туршсан. 14 хоног тутам цахим уулзалт хийж, гэрээний хүрээнд хийгдэж буй ажлуудын явцыг хэлэлцэж хэвшсэн. Мөн байгууллагын арилжаа, төлбөр тооцооны системд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлыг тестийн орчинд хийж дуусгасан байна.

## **БАГЦЫН ГЭРЭЭНИЙ СИСТЕМ**

“Биржийн байнгын бус гишүүн хоршоо, үйлдвэр хоорондын арилжаанд багцын гэрээний систем”-ийн ашиглалт хөгжүүлэлтийн гэрээг Майндсимбол компанитай байгуулсан. Гэрээний хүрээнд системийн хөгжүүлэлтийг Ибаримт 3.0 системтэй харилцан холбоотой ажиллах процессын зураглалын дагуу хийж гүйцэтгэсэн. Ибаримт 3.0 системтэй тестийн орчинд мэдээлэл солилцсон, системд хоршоо нэвтэрч хэрэглэгчээ үүсгэх, засах устгах, хэлцэлд зориулсан задаргаа оруулах боломж бүрдсэн. Баялаг гүрэм хоршоон дээр НӨАТ илгээн тест хийсэн бөгөөд систем хэрэглээнд нэвтрэхэд программ хангамжийн хувьд бэлэн болсон тул [www.bs.mce.mn](http://www.bs.mce.mn) хаяг дээр багцын гэрээний систем ажиллаж байна.

## **БУСАД ДҮРЭМ ЖУРАМ**

Мэдээлэл технологи, аюулгүй байдлын журмыг бүх ажилчдаас санал авч, захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гүйцэтгэх захирлаар батлуулж бүх ажилчид мөрдөж эхэлсэн.



## КОМПАНИЙН ВЕБ ХУУДАС

Компанийн веб хуудас [mse.mn](http://mse.mn) домэйнээр ажиллаж, нэмэлт хөгжүүлэлт, шинэчлэлийг хийж ажиллав. Нийтийн ил тод мэдээллийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай мэдээллүүдийг байршуулах, байгууллагын үйл ажиллагааг гадаад улсад сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, ажлын хүрээнд байгууллагын албан ёсны веб хуудасны англи хэлний хувилбар бий болгох, тэргүүлэх хайлтын системийн эхэнд гарч ирэх, ноолуур болон махны үнийн мэдээллийг 252BI tool ашиглан веб хуудсанд байршуулах ажлуудыг хийж гүйцэтгэв. Байгууллагын цахим хуудас байршдаг серверийг Айтүүлс ХК-ийн дата төвд байршуулаа, ингэснээр вэб сайтад хандах хурдыг 2 дахин нэмэгдүүлсэн.

## ЭКСПОРТЫН НЭГ ЦОНХНЫ СИСТЕМ

Хүнс, хөдөө аж ахуйн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Махны холбоо болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн оролцоотойгоор шинэчлэн байгуулсан Ажлын хэсэг нь “Худалдааг хөнгөвчлөх замаар хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагааг зохицуулдаг хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлтэд

экспортын үйл явцыг хөнгөвчлөх боломж, экспортын нэг цонхны цахим нэгдсэн системээр дамжуулан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход шаардах баримт бичгийн бүрдүүлбэрийн давхардлыг арилгах, “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем” нэвтрүүлэлттэй холбогдуулан өөрийн байгууллагын ашиглаж буй техникийн шинэчлэлийн шийдэлд санал боловсруулах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан ба экспортын үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын хууль, эрх зүйн орчинд зарим өөрчлөлт, шинэчлэлтийг хийн баримт бичгийн давхардлыг бууруулах саналыг боловсруулсан. Мөн эдгээр байгууллагуудыг холбосон “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийн ажил эхэлсэн ба 2023 оны эхний улиралд нэвтрүүлэлт хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.


“Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем” нь импорт, экспорт, транзиттай холбоотой зохицуулалтын бүх шаардлагыг биелүүлэхийн тулд нэг цэгээр дамжуулан төрийн байгууллагуудад мэдээлэл солилцох боломжийг олгох, хөнгөвчлөх систем бөгөөд тус системийг нэвтрүүлэх нь төрийн байгууллагуудын баримт бичгийн давхардлыг арилгах, түүнд зарцуулагдах цаг хугацаа, зардалыг бууруулахад бодит дэмжлэг болох юм.



# МАРКЕТИНГ

2023 оны 1-р сарын 02-ны өдрөөс эхлэн компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 149,400 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 362 хувиар өссөн байна.

Тайланд онд цахим хуудсанд нийт 293 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж ажилласан байна. Үүнээс 236 мэдээний постерийн эхийг бэлтгэсэн ба 11 видео шторк хийж гүйцэтгэлээ.



## Өмнөх оны мөн үетэй харьцуулбал



Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор bataar.mn, tsenzuur.mn, newslife.mn, social.mn, tac.mn, parliament tv, zuvchig.mn, Монголчууд сэтгүүл зэрэг телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж

мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Үндсэн үйл ажиллагааны долоо хоног тойм мэдээллийг Bloomberg TV-тэй хамтран мэдээний буланд байршуулж олон нийтэд хүргэн ажилласан..



Гадаадын зах зээлийн хэрэглэгчдэд компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор англи хэл дээр хэвлэмэл болон цахим танилцуулга хийж гүйцэтгэсэн.

“Ноолуурын дуудлага худалдаа”-ны гарын авлага, танилцуулгын эх бэлтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Олон нийтэд танилцуулга, гарын авлагыг утас, таблет, компьютерээс шууд үзэж танилцах боломжийг бий болгох зорилгоор цахим хэлбэрээр хийсэн байна. Мөн дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдуулан олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх, идэвхжүүлэх, сурталчлан таниулах ажлын төлөвлөгөө боловсруулж шат дараатайгаар хэвлэл мэдээллийн байгууллагууд болох сонин, сэтгүүл, мэдээний сайт, телевизүүдтэй хамтран ажилласан.

Компанийн 10 жилийн ойг тохиолдуулан идэвхжүүлэлтийн ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, компанийн брендингийг хөгжүүлэх зорилгоор “10 жил хөдөө аж ахуйн бирж” гэсэн логог зохион бүтээж шинэчилсэн.

Нийслэл, Увс, Завхан аймгуудад 2023 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан “Малын төвлөрсөн арилжаа”-ны бэлтгэл ажлын хүрээнд баннер, цахим танилцуулга, постер зэргийг хийж гүйцэтгэсэн ба арга хэмжээг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчлан таниулах, олон нийтэд

мэдээ, мэдээллээр хангах зорилгоор mnb.mn, medee.mn, montsame.mn, ubn.mn, zogii.mn, zuv.mn, eagle.mn, unuudur.mn, news.mn, toim.mn, zindaa.mn, tsenzuur.mn, newslife.mn, tac.mn, bataar.mn, social.mn, dandaa.mn, asuudal.mn, mpress.mn, 24barimt.mn, newswire.mn, mpress.mn, tusgal.mn, m21.mn 24 сайтуудаар дамжуулж олон нийтэд түгээсэн. Мөн ТВ24 телевиз, МҮОНРТ-ийн Монголын мэдээ хөтөлбөрөөр мэдээ бэлтгэн ТВ-ээр гаргасан.

**Та доорх QR код уншуулан бусад түүхий эдийн анхан шатны тордолт, чанар стандартын дагуу бэлтгэх гарын авлагатай танилцана уу**



Хонины ноос  
бэлтгэх



Ямааны ноолуур  
бэлтгэх



Тэмээний ноос  
бэлтгэх



Арьс шир  
бэлтгэх



# ЗАХИРГАА, САНХҮҮ

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

“Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан, Улсын Их хурлын байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд бусад хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэй байхаар боловсруулаад байгаа бөгөөд уг хуулийн төслийг 2023 оны Улсын их хурлын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхээр “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо”-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хийж гүйцэтгээд байна.

Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулан шинэчлэн найруулж 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдөр Гүйцэтгэх захирлын А/58 дугаар тушаалын хавсралтаар тус журам, хөдөлмөрийн гэрээний загварыг батлуулж, ажилтан, ажил олгогч хоорондын үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтыг зохицуулан хэрэгжүүлж ажиллалаа.

Иргэн Б.Тумар, Х.Баатар нартай холбоотой компанид учруулсан хохиролд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэж иргэн Х.Баатараас нийт 16,798,375 төгрөг, мөн тус шүүх хуралдаанд оролцоход нэхэмжлэгчээс төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг тус тус гаргуулан олгохоор шийдвэрлүүлээ.

Компанийн эрх бүхий 11 албан тушаалтны 2022 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг батлагдсан маягтын дагуу дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд нь хүргүүлж тайлагнан, 2022\* оны Компанийн эрх бүхий 12 Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг баталгаажуулан ажиллалаа.



“Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдтэй байгуулах 16 төрлийн гэрээний төсөл боловсруулж нийт 73 гэрээг байгуулав. Үүнд: Лицензийн гэрээ 1, Программ хангамжийн лиценз нийлүүлэх гэрээ 1, автомашины дуудлагын үйлчилгээ үзүүлэх гэрээ 1, хөдөө ажлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх гэрээ 1, ажилтнуудыг сургалтанд хамруулах гэрээ 2, автомашины түрээсийн гэрээ 2, захиалгын гэрээ 2, ажлын байрны зориулалтаар өрөө түрээслүүлэх гэрээ 1, блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн системийн ашиглалтад дэмжлэг үйлчилгээ үзүүлэх гэрээ 1, Программ хангамж хөгжүүлэх гэрээ 2, Зөвлөх үйлчилгээний 3 гэрээ, Арга хэмжээ зохион байгуулах гэрээ 2, Тоног төхөөрөмж түрээслэх гэрээ 1, Хамтран ажиллах гэрээ 1, Судалгааны ажил гүйцэтгэх гэрээ 8, Ажил гүйцэтгэх гэрээ 47 гэрээг тус тус байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Агуулах итгэмжлэх үйл ажиллагааг MNS-ISO 17065 стандарт нийцүүлэх зөвлөх үйлчилгээ авах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад тэнцсэн “ДАТ консалтинг” ХХК-тай байгуулсан Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний талаарх мэдээллийг хуулийн хугацаанд тайлагнав.

## ДОТООД ХЯНАЛТ, МОНИТОРИНГ

Хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдүүлж, журмын хэрэгжилтийг хангахад хяналт тавих зорилгоор дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан ажиллалаа.

### Үүнд:

Арилжаа, Клиринг төлбөр тооцоо, Гишүүнчлэлийн эрх итгэмжлэл олгох үйл ажиллагаа;



Цахим хөгжүүлэлт арилжааны хяналт;



Нийцлийн хяналт;



Гүйцэтгэлийн хяналт ;





## САНХҮҮ, АЖ АХУЙ

Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр, сар бүр, улирал тутам, хагас жил, бүтэн жилээр оруулах 134 мэдээллийг хуулийн хугацаанд нь тогтмол оруулахаас 134 мэдээллийг хугацаанд нь оруулж ажиллалаа. Тус хуулийн 6 дугаар зүйлд заасан зарим мэдээллийг шилэн дансны цахим системд, худалдан авах ажиллагааны цахим систем ([tender.gov.mn](http://tender.gov.mn))-д худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон шаардлагатай мэдээллийг хуулийн хугацаанд оруулан байршууллаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Компанийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу компанийн борлуулалтын орлого болон худалдан авалтын тооцоог долоо хоногоор хийж, цахим төлбөрийн баримтыг нэг бүрчлэн тулгаж, сар бүр харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн хуулийн хугацаанд нь тайлагнаж байна.

Нийгмийн даатгалын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын дагуу компанийн ажилтнууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлснөөс хуульд заасан хувь хэмжээгээр татварыг суутган авч холбогдох маягтын дагуу хуулийн хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.

Компанийн санхүү, бүртгэл, мөнгөн хөрөнгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг иж бүрэн хөтөлж, санхүүгийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн программаар тайлан баланс гаргаж байна.

Компанийн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх судалгаанд дүгнэлт хийж, төсвийн төсөл, төсөөллийг бодитой боловсруулсны үндсэн дээр 2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр борлуулалтын орлого 93 хувийг татан төвлөрүүлж, зардлын гүйцэтгэл 99 хувь буюу зардлын хэтрэлтгүй ажиллаж байна.

Компанийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бараа материал, үндсэн хөрөнгөнд хуулийн дагуу тооллого явуулж, илүүдэлтэй болон ашиглагдахгүй байгаа, эвдэрсэн үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт танилцуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хурлаар холбогдох шийдвэрийг гаргуулахаар хүлээж байна.



## ХҮНИЙ НӨӨЦ

Байгууллагыг чадварлаг хүний нөөцөөр тасралтгүй ханган ажиллах, ажилтнуудын нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, цалин урамшуулал, идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор биржийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулж дараах байдлаар ажиллалаа.

**Үүнд:** Хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан шинэчлэн батлав. Ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ёсоор 9 төрлийн сургалтад 60 ажилтныг хамруулан сургалаа. Гэр бүл ба хүүхдэд зарцуулах цагийг уян хатан зохицуулж ажлын гүйцэтгэлийг сайжруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Уян хатан цагийн хуваарь”-ийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр ХЭГ/595 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангаж, хариу хүргүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд компанийн хэмжээнд ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын болон бусад шаардлагыг хангаагүй 5 ажилтан тогтоогдсон тул тухайн

ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4-т заасны дагуу мэдэгдэл өгч, 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тасалбар болгон Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцалж шийдвэрлэн дүнг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ХХААХҮЯ, Төлөөлөн удирдах зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус хүргүүлсэн.

## АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 135 тушаал, хүний нөөцтэй холбоотой 72 тушаал, албан бичиг 305 -ыг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, заавар, журмын дагуу албажуулан, 120 бичиг хүлээн авч бүртгэн, удирдлагын цохолтоор хэлтсүүдэд хуваарилан хариуг гаргуулж, бүртгэл хяналтын карт хөтлөн, хариутай буюу хугацаатай 55 бичгийн хариуг хугацаанд нь хүргүүллээ.

Салбарын удирдлагаас өгсөн 43 удаагийн үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хэлтэс, албан тушаалтнаар гаргуулан Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж үнэлүүлэн компанийн сарын томоохон ажлын тайланг хэлтэс бүрээр гаргуулан нэгтгэж сар бүр Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулан ажиллалаа.



Гүйцэтгэх захирлын 32 удаагийн шуурхай хуралдааны тэмдэглэл хөтөлж албажуулан, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг нэгтгэж хэлтсүүдэд хүргүүлэх, хэрэгжилтийг нэгтгэж танилцуулсан

2023 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар захирлын зөвлөлийг байгуулсан бөгөөд 4 удаагийн хурлын бэлтгэл ажлыг ханган, тэмдэглэл хөтөлж, шийдвэрийг албажуулсан.



# СУРГАЛТ, ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭ

Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн Засаг Бизнесийн Сургуулийн Статистик, Эконометрикийн тэнхимээс зохион байгуулж буй биржийн мэргэжилтнүүдэд “Судалгааны арга зүй” мэргэжил дээшлүүлэх сургалтад 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн дуустал хугацаанд хамрагдсан.

Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг иргэд, олон нийт, төрийн алба хаагчдад сурталчлан таниулах сургалтад тус компаниас 3 ажилтан оролцсон

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого” сургалтанд 4 хоног цахим, 2 хоног танхимын сургалтанд хамрагдаж, цахимаар 2 удаа сургалтын агуулгаар шалгалт амжилттай өгч сертификат авах болзлыг хангав.

Компанийн нийт ажилтнуудын дунд “Мэдлэг солилцох өглөөний арга хэмжээ” сургалтыг хэлтэс тус бүр ээлжлэн 14 хоног тутам тогтмол зохион байгуулаж байна.

Стандарт Хэмжил Зүйн Газраас зохион байгуулсан “Стандартчиллын суурь асуудал М1-баталгаажуулалтын шинжээч” болон “Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох М-2” танхимын сургалтад гишүүнчлэл бүртгэлийн хэлтсийн 5 мэргэжилтэн хамрагдан гэрчилгээ авсан.

## АЖЛЫН ХЭСЭГ

Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан ложистикийн төвийг хэрхэн ажиллуулах тооцоолол хийх, түрээслүүлэх шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдөр А/69 дүгээр тушаалаар Ложистикийн төвийн түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж Зайсан инвест агро ХХК-г сонгон шалгаруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, түрээслэгч талтай гурван талт гэрээ байгууллаа. Түрээслэгч тал ашиглалтын болон харуул хамгаалалтын зардлыг бүрэн хариуцах ба 2022 он дуустал сарын 3.0 сая, 2023 оноос 4.5 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлнө.



Цахим бирж болох ажлын хүрээнд компанийн үйл ажиллагааг аппликэйшн хэлбэрт оруулах, биржийн цахим хуудсыг хөгжүүлэх, төсөв, төлөвлөгөөг гаргах ажлыг судлах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг 2022 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/78 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг ажлын хэсгийн хүрээнд гаднын орнуудын хөрөнгийн биржийн цахим сайтын үйл ажиллагааг судлах, тэдний давуу болон сул тал, аппликэйшн хийгдсэн эсэх талаар судалгаа гаргах, биржийн үйл ажиллагааг хэрхэн цахим хэлбэрт оруулах иргэд, аж ахуйн нэгжид үйлчилгээг ойртуулах талаар судалгааны ажил хийгдэж байна. Эхний ажлын хүрээнд Айтүүлс ХК-тай хамтран цахим хуудсанд дуудлага худалдааг холбох ажил хийгдэж 90%тай явагдаж байна. Ингэснээр иргэд, ААН-д хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийг дуудлага худалдаагаар худалдан авах болон худалдах боломжоор хангагдах юм.

Бирж, татварын байгууллага болон биржийн байнгын бус гишүүн хоршооны хооронд “Багцын гэрээ” байгуулах ажлыг гүйцэтгэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Гүйцэтгэх захирлын А/38 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хэсгийн хүрээнд бирж, татварын байгууллага болон биржийн байнгын бус гишүүн хоршооны хооронд байгуулах “Багцын гэрээ”-ний төсөл боловсруулж, биржийн арилжаанд оролцогч талууд

яаж оролцох талаар ойлголт өгөх ерөнхий зураглалыг гаргаж, багцын гэрээний системийн хөгжүүлэлтийг хийх компанитай 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгууллаа. Тус ажлуудыг хийснээр 2023 оны хувьд дотоодын үйлдвэрүүд хоршоогоор биржийн арилжаанд орсноор нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4-т “Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр, мах боловсруулах үйлдвэрлэлд зориулан бэлтгэх таван хошуу мал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар хасалт хийнэ” гэсэн заалт хэрэгжих боломжтой болсноор дотоодын үйлдвэрүүдэд давуу талтай болж дотоод арилжаанд орох сонирхол бий болно. Иймд 2023 оны хувьд дотоодын үйлдвэрүүдэд “Багцын гэрээ”-ний талаар сурталчлан таниулах, мэдүүлэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.



Монгол Улсад нутагшуулан, үржүүлж байгаа импортын өндөр ашиг шимт малын дуудлага худалдааг зохион байгуулах, дэмжин ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хүрээнд дуудлага худалдаанд оролцогчдод удирдамж боловсруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн, Малын дуудлага худалдааны түр журам боловсруулах, мөн худалдах худалдан авах гэрээг боловсруулж байна. Дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой үүсэх эрсдэлийг тодорхойлсон. Айтүүлс ХК-тай дуудлага худалдааны программыг туршилтаар дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд нэмэлт хөгжүүлэлт хийхээр харилцан тохиролцоод байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/294 дүгээр тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/372 дүгээр тушаалаар Дэд сайдаар ахлуулан Хүнс, хөдөө аж ахуйн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Махны холбоо болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн оролцоотойгоор шинэчлэн байгуулсан Ажлын хэсэг нь “Худалдааг хөнгөвчлөх замаар хөдөө аж ахуйн гаралтай.

бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагааг зохицуулдаг хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлтэд экспортын үйл явцыг хөнгөвчлөх боломж, экспортын нэг цонхны цахим нэгдсэн системээр дамжуулан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход шаардах баримт бичгийн бүрдүүлбэрийн давхардлыг арилгах, “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем” нэвтрүүлэлттэй холбогдуулан өөрийн байгууллагын ашиглаж буй техникийн шинэчлэлийн шийдэлд санал боловсруулах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан ба экспортын үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын хууль, эрх зүйн орчинд зарим өөрчлөлт, шинэчлэлтийг хийн баримт бичгийн давхардлыг бууруулах саналыг боловсруулсан. Мөн эдгээр байгууллагуудыг холбосон “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийн ажил эхэлсэн ба 2023 оны эхний улиралд нэвтрүүлэлт хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.

“Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем” нь импорт, экспорт, транзиттай холбоотой зохицуулалтын бүх шаардлагыг биелүүлэхийн тулд нэг цэгээр дамжуулан төрийн байгууллагуудад мэдээлэл солилцох боломжийг олгох, хөнгөвчлөх систем бөгөөд тус системийг нэвтрүүлэх нь төрийн байгууллагуудын баримт бичгийн давхардлыг арилгах, түүнд зарцуулагдах цаг хугацаа, зардалыг бууруулахад бодит дэмжлэг болох юм.



# ДҮГНЭЛТ

Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон 2023 оны Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн хангаж ажиллаж хэд хэдэн томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан ажилласан байна.



Тайлант хугацаанд 220 удаагийн арилжаа зохион байгуулж, нийт 968.2 тэрбум төгрөгийн 1662 хэлцэл хийсэн. Үүнд 6300 тонн ямааны ноолуур, 2379 тонн ямааны завод ноос, 10554.4 тонн хонины ноос, 987 тонн тэмээний ноос, 22321 тонн тосны ургамал /рапс/, 16.0 тонн тэмээний очёс, 228 тонн завод ноос, 8.6 тонн бодын хөөвөр, 4400 ширхэг үхрийн шир, 1441 толгой амьд мал зэрэг бараа, түүхий эдийг арилжлаа.



2023 онд 7 байнгын гишүүн брокерын компани, 1 байнгын бус гишүүн хоршоогоор зуучлуулан 68 аж ахуйн нэгж биржийн арилжаанд оролцон 1568 ширхэг бараа, түүхий эдийн экспортын тодорхойлолт авав.



“Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан, байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.



Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд бусад хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэй байхаар боловсруулаад байгаа бөгөөд уг хуулийн төслийг 2023 оны Улсын их хурлын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхээр “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо”-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хийж гүйцэтгэлээ.



2023 оны байдлаар 7 байнгын гишүүн, 86 байнгын бус гишүүн, үйлдвэрийн дэргэдэх 23 агуулах, орон нутаг дахь 118 агуулахтай үйл ажиллагаа явуулж, хамтран ажилласан байна.



Биржийн арилжаанд оролцох мэргэжлийн оролцогчийг бэлтгэх, мэргэшүүлэх зорилгоор “Брокерын эрх олгох” сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн мэргэжлийн холбоотой хамтран 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 5 дугаар 12-ны өдрүүдэд 25 оролцогчийг хамруулан зохион байгуулан гэрчилгээг олгосон.



“Экспортын нэг цонхны систем”-ийг нэвтрүүлэн мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын бүрдүүлэлтийг хийх нэг удаагийн гүйцэтгэлийн хугацааг 316 цагаас 72 цаг хүртэл бууруулан, хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орсноор “50” гаруй баримт бичгийг “11+4” болгон багасгаж чадлаа. Тайлант хугацаанд 696 экспортын үйл ажиллагааны хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, 27,695.37 тонн мах экспортод гаргаад байна.



2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр биржийн Ложистикийн төв дээр малчин болон үйлдвэрийг холбосон дундын зуучлалгүй арилжааг зохион байгуулан 4 аймгийн 10 гаруй сумдаас ирсэн 629 толгой бог малыг мах боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх спот гэрээний, 600 бог малын форвард гэрээний арилжааг тус тус хийлээ.

Мөн 2023 оны 11 дүгээр сард Малын Удмын Сангийн Үндэсний төвийн цөм сүргийн салбар нэгжийн малаас Увс аймагт 435 толгой бог, Завхан аймагт 350 толгой бог малыг тус тус биржээр дамжуулан зах зээлд нийлүүлэх малын форвард гэрээний арилжааг зохион байгуулснаар нийт 2014 толгой малыг малын төвлөрсөн арилжаагаар арилжжээ.



Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа хэлтэс тус бүр хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ



[www.mce.mn](http://www.mce.mn)



70128779, 70148779



Хөдөө Аж Ахуйн Бирж ТӨХХК



Энхтайвны өргөн чөлөө, 18А-1, Монголын Хөдөө Аж Ахуйн  
Хоршоологчдын Үндэсний Холбооны байр, 2 давхар